



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
ЕРӨНХИЙ ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу 13/1, Утас: 32 80 30, Факс: (976-11) 32 07 16,  
E-mail: undeg@ndaatgal.mn, http://www.ndaatgal.mn

2020. 01.24 № 3/153  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**АЙМАГ (НИЙСЛЭЛ), ДҮҮРГИЙН  
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС  
(ГАЗАР)-ИЙН ДАРГА НАРТ**

Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 483 дугаар тогтоолоор баталсан “Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэний тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх журам”, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/08 тоот тушаалаар баталсан “Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэний тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх журмыг хэрэгжүүлэх заавар”-ыг тус тус хүргүүлж байна.

Дээрх журам, зааврыг нийт байцаагч, ажилтнуудад танилцуулан, иргэд, малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд сурталчилан, хэрэгжилтийг зохион байгуулахыг мэдэгдэе.

Хавсралт 21 хуудастай.

БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ,  
СУДАЛГААНЫ ГАЗРЫН  
ДАРГА

Ц.ГАНЦЭЦЭГ



9051733 1118150293 AMT

My doc.BHSG. A-5 /20.01-r sar/

515150293



**НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2020 оны 01 сарын 23 өдөр

Дугаар А/08

Улаанбаатар хот

Заавар батлах тухай

Нийгмийн даатгалын тухай хуулийн 24 дүгээр зүйл, Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, Засгийн газрын 2014 оны 354 дүгээр тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын байгууллагын дүрэм”-ийн 3.1.2, 3.2.4 дэх заалт, Засгийн газрын 2019 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэний тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх журам”-ын 9.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. “Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэний тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх журмыг хэрэгжүүлэх заавар”-ыг нэгдүгээр, “Тэтгэврийн даатгалын шимтгэл нөхөн төлөх иргэний хүсэлтийн загвар”-ыг хоёрдугаар, тэтгэврийн даатгалын шимтгэл нөхөн төлүүлэх болон баталгаажсан иргэдийн бүртгэлийн маягыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Аймаг (нийслэл), дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс (газар)-ийн дарга нарт үүрэг болгох нь:

2.1. Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хууль, журам болон батлагдсан зааврын дагуу иргэдэд зөвлөгөө, мэдээлэл өгөх, хүсэлтийг нь хүлээн авч шийдвэрлэх асуудлыг батлагдсан орон тоондоо багтаан тэтгэврийн нэг байцаагчид, хэрэгжилтийг зохион байгуулах чиг үүргийг Үйлчилгээний тасгийн даргад, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг Дотоод аудит, хяналтын тасгийн даргад тус тус хариуцуулах;

2.2. Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хууль, журам болон батлагдсан зааврын дагуу аймаг, сум, дүүргийн хэмжээнд малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэнийг бүртгэх, баримт бичгийг бүрдүүлэх, төлсөн шимтгэлийг хянах, баталгаажуулах ажлыг шуурхай зохион байгуулж, ажлын үр дүнг тооцон тайланг 2021 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор Бодлогын хэрэгжилт, судалгааны газарт ирүүлэх.

515110027

Гурав. Энэхүү зааврыг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Бодлогын хэрэгжилт, судалгааны газар (Ц.Ганцэцэг), холбогдох програм хангамжийг бодлогын даалгаврын дагуу боловсруулж, Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах болон иргэдийн хүсэлтийг энэ тушаалаар баталсан маягт, баталгаажилтын хуудсыг хэвлэх боломжийг бүрдүүлэн 2020 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн дотор аймаг, дүүргийн хэлтсүүдэд хүргүүлэхийг Мэдээллийн технологийн төв (Г.Хүрэлбаатар), тэтгэврийн даатгалын сангийн харилцах дансанд нэг удаа нөхөн төлсөн шимтгэлийг бүртгэж тооцоо хийсэн үндэслэлд хяналт тавьж ажиллахыг Санхүү бүртгэлийн газар (Б.Даваахүү), хууль тогтоомжийн хэрэгжилтийг нийгмийн даатгалын хэлтсүүдэд шалгаж, илэрсэн зөрчил дутагдлыг цаг хугацаанд нь шуурхай шийдвэрлэж ажиллахыг Хяналт шалгалтын газар (Д.Ганзориг)-т тус тус даалгасугай.

Дөрөв. Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэл нөхөн төлүүлэх тухай хуулийн хэрэгжилтийн дүнг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Даргын зөвлөлд танилцуулан, тайланг 2020 оны 01 дүгээр улиралд багтаан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэхийг Бодлогын хэрэгжилт, судалгааны газар (Ц.Ганцэцэг)-т үүрэг болгосугай.

Тав. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дэд дарга (Г.Саран)-д даалгасугай.

ДАРГА  Д.ЗОРИГТ



НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
ЕРӨНХИЙ ГАЗАР


МАЛЧИН, ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧ ИРГЭНИЙ ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН  
ШИМТГЭЛИЙГ НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ ЖУРМЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗААВАР


Баримт бичгийн дугаар: ЗВР-НДБХСГ- 01- 2020

Баталсан: Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга  Д.Зоригт

Хянасан: Бодлогын хэрэгжилт, судалгааны газрын дарга  Ц.Ганцэцэг

Боловсруулсан: Бодлогын хэрэгжилт, судалгааны газрын ахлах мэргэжилтэн  С.Лхагвадорж

Бодлогын хэрэгжилт, судалгааны газрын мэргэжилтэн  П.Эрдэнэ

Эх хувь	
Хяналттай хувь	
Хуулбар ба хяналттай хувь	
Хүчингүй хувь	

Дардас

Баримт бичгийн үзүүлэлт




Баримт бичгийн үзүүлэлт

Журмын хариуцагч	Тушаалын дугаар	Баталсан огноо	Мөрдөж эхлэх огноо	Хуудасны тоо
НДЕГ-ын НДБХСГ	A/08	2020-01-23	2020-01-01	....

Өөрчлөлтийн тухай тэмдэглэл


Хувилбар	Өөрчлөлт оруулсан огноо	Өөрчлөлтийн утга	Өөрчлөлт оруулсан ажилтан
Хувилбар 1			
Хувилбар 2			
Хувилбар 3			
Хувилбар 4			
Хувилбар 5			
Хувилбар 6			





## АГУУЛГА

1. Зорилго
2. Хамрах хүрээ
3. Хамаарах талууд
4. Баримт бичгийн хариуцагч
5. Үндсэн хэсэг
6. Хариуцлага





Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын  
2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн  
А/08 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

МАЛЧИН, ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧ ИРГЭНИЙ ТЭТГЭВРИЙН  
ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙГ НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ ЖУРМЫГ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗААВАР

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хууль, Засгийн газрын 2019 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэний тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх журам”-ын дагуу малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэний 1995-2019 онд төлөгдөөгүй тэтгэврийн даатгалын шимтгэлийг нэг удаа нөхөн төлүүлэх ажлыг зохион байгуулахад энэхүү зааврыг мөрдөнө.

ХОЁР. Хамрах хүрээ

2.1. 1995-2019 он (цаашид “нөхөн төлөх хугацаа” гэх)-д тэтгэврийн даатгалын шимтгэлээ төлөөгүй малчнаар ажиллаж байсан “Мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн тооллого”-ын бүртгэл (цаашид “А” данс” гэх) бүхий иргэн; хувиараа хөдөлмөр эрхэлж байсан хугацаандаа татварын албанд бүртгүүлж хувь хүний орлогын албан татварын төрөлд хамаарах татвар төлсөн иргэн (цаашид “иргэн” гэх).

ГУРАВ. Хамаарах талууд

3.1. Нийгмийн даатгалын ерөнхий газар, Нийслэлийн нийгмийн даатгалын газар, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсүүд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам (цаашид “БСШУСЯ” гэх), Татварын ерөнхий газар (цаашид “ТЕГ” гэх), Цагдаагийн ерөнхий газар (цаашид “ЦЕГ” гэх), Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар (цаашид “ШШГЕГ” гэх), Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар (цаашид “ХХҮЕГ” гэх).

ДӨРӨВ. Баримт бичгийн хариуцагч

4.1. Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, судалгааны газар, Хяналт, шалгалтын газар, Санхүү бүртгэлийн газар, Мэдээллийн технологийн төв.

ТАВ. Үндсэн хэсэг

5.1. Энэ зааврын 1.1-д заасан дараах нэр томъёог доор дурдсанаар ойлгоно:

5.1.1. “малчин” гэж мал аж ахуй эрхэлж үндсэн орлогоо олдог “А” данс бүхий иргэнийг;



5.1.2. “хувиараа хөдөлмөр эрхлэгч” гэж дангаараа болон бусадтай хамтран аж ахуй эрхэлж, татварын албанд бүртгүүлэн бизнесийнхээ үйл ажиллагаанд нөлөөлөх шийдвэрээ хараат бусаар бие даан гаргадаг, татвар төлсөн иргэнийг.

5.2. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан өндөр насны тэтгэвэр, нийгмийн халамжийн тэтгэвэр, цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгоогүй, 15-60 насны (61 нас хүртэл) энэ зааврын 5.1-д заасан иргэний 1995-2019 онд малчнаар ажилласан буюу “А” данстай байсан хугацаа, хувиараа хөдөлмөр эрхэлж байсан буюу татвар төлсөн хугацаанд төлөгдөөгүй тэтгэврийн даатгалын шимтгэлийг нэг удаа нөхөн төлүүлнэ.

5.3. “Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэний тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх журам”-ын 4.6-д заасны дагуу малчнаар ажилласан болон хувиараа хөдөлмөр эрхэлснээс бусад хугацааны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэхгүй.

5.4. Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хууль хүчин төгөлдөр болох хүртэл хугацаанд нас барсан энэхүү зааврын 5.1.1, 5.1.2-т заасан иргэн энэ хуулийн үйлчлэлд хамаарахгүй.

*Санамж<sup>1</sup>: Малчин, хувиараа хөдөлмөр эрхэлсэн хугацаанд иргэний эдгээрээс бусад төрлийн ажил, хөдөлмөр эрхэлсэн болон хууль тогтоомжийн дагуу нийгмийн даатгалын болон нийгмийн халамжийн сангаас өндөр насны, цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгосон, бүх төрлийн сургуулийн өдрийн ангид суралцсан, хорих ял эдэлсэн хугацаа хамаарахгүй.*

*Санамж<sup>2</sup>: Нийгмийн даатгалын байцаагч нь тэтгэврийн даатгалын шимтгэл нөхөн төлөхийг хүссэн иргэний холбогдох баримт бичгийг нягтлан үзэж, зөвлөгөө мэдээлэл өгч, төлбөл зохих шимтгэлийг тэтгэврийн даатгалын санд бүрэн төлсний дараа мэдээллийн санд бүртгэнэ.*

5.5. Иргэн нь тэтгэврийн даатгалын шимтгэлийг нэг удаа нөхөн төлөх хугацааг тогтоолгох тухай хүсэлтийг энэ зааврын 5.10, 5.11-д заасан холбогдох баримт бичгийн хамт бүрдүүлж оршин суугаа нутаг дэвсгэрийн харьяалах нийгмийн даатгалын байгууллага (байцаагч)-д ирүүлнэ.

5.6. Нийгмийн даатгалын байгууллага (байцаагч) энэ зааврын 5.1-д заасан иргэний энэ зааврын 5.5-д заасан холбогдох баримт бичгийн бүрдэлт, үндэслэлийг нягтлан шалгасны үндсэн дээр тэтгэврийн даатгалын шимтгэлийг нэг удаа нөхөн төлөх хугацаа (жилийг)-г тогтооно.

5.7. Нийгмийн даатгалын байгууллага (байцаагч) нь “Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэний тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх журам”-ын 6.3-т заасны дагуу шимтгэл нөхөн төлсөн иргэн бүрт хувийн хэрэг нээнэ:





5.7.1. Хувийн хэрэгт Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэл нөхөн төлүүлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, “Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэний тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх журам”-ын 5.2-5.4-т заасан баримт бичиг болон өргөдөл гаргагчийн хүсэлтийг хавсаргана.

5.7.2. Сумын нийгмийн даатгалын байцаагч нь энэ зааврын 5.6-д заасан хугацааг тооцон, тэтгэврийн даатгалын шимтгэл нөхөн төлөх хүсэлт гаргасан иргэн бүрт энэ зааврын 5.7-д заасан хувийн хэргийг нээж аймгийн нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлнэ.


5.8. Нийгмийн даатгалын байгууллага (байцаагч) нь нөхөн төлөх хугацаанд шимтгэл нөхөн төлүүлэхээр шалгаж тогтоосон хугацааны тэтгэврийн даатгалын шимтгэлийг сард 42 000 төгрөг (420 000 төгрөгөөс 10 хувиар)-өөр бодон нийт төлөх шимтгэлийн хэмжээг тооцож, тухайн иргэнээр тэтгэврийн даатгалын сангийн харилцах дансанд нь нэг удаа бүрэн төлүүлнэ.

5.9. Нийгмийн даатгалын байгууллага (байцаагч) энэ зааврын 5.6-д заасны дагуу нөхөн төлөх хугацаанд шимтгэл нөхөн төлүүлэхээр шалгаж тогтоосон хугацааны тэтгэврийн даатгалын шимтгэлийг тухайн иргэнээр доор дурдсан журмаар нөхөн төлүүлж, уг орлогын мэдүүлгийн баримтыг авч бүртгэнэ:

5.9.1. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7-д зааснаар нийт шимтгэл төлсөн хугацааг хангасан боловч малчнаар ажиллаж шимтгэл төлсөн байвал зохих хугацаа (эрэгтэй 15 жил, эмэгтэй 12 жил 6 сар)-г хангаагүй тохиолдолд зөвхөн уг хугацааны тэтгэврийн даатгалын шимтгэлийг энэ зааврын 5.11.6, 5.11.7, 5.11.8-д заасан тодорхойлолт, “А” дансны архивын лавлагаа, “Даатгуулагчийн малчнаар ажиллаж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тодорхойлох зөвлөл”-ийн тогтоолыг тус тус үндэслэн нөхөн төлүүлэхээр зөвлөгөө өгнө.

*Санамж<sup>3</sup>: 1961 оны 6 дугаар сарын 1-ний өдөр төрсөн, 58 настай эрэгтэй, нийгмийн даатгалын шимтгэлийг 2020 он хүртэл нийтдээ 25 жил төлж ажилласны дотор малчнаар 2011-2020 оны хооронд 10 жил ажиллаж, сайн дурын даатгалд даатгуулж, шимтгэл төлсөн малчин даатгуулагч нь 2001-2010 онд 10 жил мал маллаж байх хугацаандаа тэтгэврийн даатгалын шимтгэл төлж чадаагүй гэвэл тухайн малчин даатгуулагчийн шимтгэл төлөөгүй 10 жилээс зөвхөн малчнаар дутуу ажилласан 5 жилийн шимтгэлийг 2 520 000 төгрөг(42 000 төг х 60 сар)-өөр тооцож нөхөн төлүүлнэ.*

*Санамж<sup>4</sup>: 1963 оны 10 дугаар сарын 1-ний өдөр төрсөн, 56 настай эрэгтэй, нийгмийн даатгалын шимтгэлийг 2020 он хүртэл нийтдээ 15 жил төлж ажилласны дотор малчнаар 8 жил ажиллаж, сайн дурын даатгалд даатгуулж, шимтгэл төлсөн малчин даатгуулагч нь 1995-2012 онд 17 жил мал маллаж байх хугацаандаа тэтгэврийн даатгалын шимтгэл төлж чадаагүй байсан гэвэл тухайн иргэний шимтгэл төлөөгүй 17 жилээс зөвхөн малчнаар дутуу ажилласан 7 жилийн шимтгэлийг 3 528 000 төгрөг (42 000 төг х 84 сар)-өөр тооцож нөхөн төлүүлнэ.*





5.9.2. Энэ зааврын 5.11, 5.12-т заасан баримт бичгийг үндэслэн тооцсон шимтгэл төлж ажилласан хугацаа болон Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиар тогтоосон өндөр насны бүрэн, эсхүл хувь тэнцүүлсэн тэтгэвэр тогтооход баримтлах шимтгэл төлсөн байвал зохих доод хугацаа (өндөр насны бүрэн тэтгэврийг тогтоолгоход баримтлах шимтгэл төлсөн байвал зохих доод хугацаа эсхүл хувь тэнцүүлсэн тэтгэвэр тогтоолгох жил)-ны хоорондын зөрүү буюу дутуу хугацааны шимтгэлийг тухайн иргэнээр энэ зааврын 5.12.2-т заасан баримтыг үндэслэн нөхөн төлүүлнэ.


*Санамж<sup>5</sup>: 1968 онд төрсөн 52 настай эмэгтэй, нийгмийн даатгалын шимтгэлийг 2020 он хүртэл нийтдээ 15 жил төлсөн иргэн нь хувиараа хөдөлмөр эрхэлж байх хугацаандаа шимтгэл төлөөгүй 14 жилээс зөвхөн өндөр насны бүрэн тэтгэвэр 55 насандаа тогтоолгоход баримтлах шимтгэл төлсөн байвал зохих доод хугацаа болох 21 жил 9 сард хүргэхэд шаардлагатай 6 жил 9 сард ногдох 3 402 000 төгрөг (42 000 төг х 81 сар)-ийн шимтгэлийг нэг удаа нөхөн төлүүлнэ.*

*Санамж<sup>6</sup>: 1966 оны төрсөн 55 настай эрэгтэй, нийгмийн даатгалын шимтгэлийг 2020 он хүртэл нийтдээ 17 жил төлсөн иргэн нь 2008-2019 оны хооронд хувиараа хөдөлмөр эрхэлж байх хугацаандаа тэтгэврийн даатгалын шимтгэл төлж чадаагүй бол шимтгэл төлөөгүй 11 жилээс зөвхөн өндөр насны бүрэн тэтгэвэр 60 насандаа тогтооход баримтлах шимтгэл төлсөн байвал зохих доод хугацаа 22 жил 3 сард хүргэхэд шаардлагатай 5 жил 3 сард ногдох 2 646 000 төгрөг (42000 төг х 63 сар)-ийн шимтгэлийг нөхөн төлүүлнэ.*

5.9.3. Нөхөн төлөх нийт хугацаанд тэтгэврийн даатгалын шимтгэлийг огт төлөөгүй хувиараа хөдөлмөр эрхэлж байсан иргэний энэ зааврын 5.12.2-т заасан баримт бичгийг үндэслэн өндөр насны тэтгэвэр тогтоолгоход шаардлагатай нийт жилд ногдол шимтгэлийг нөхөн төлүүлнэ.

*Санамж<sup>7</sup>: 1960 оны 01 дүгээр сарын 01-нд төрсөн, хүсэлт гаргах үед 60 нас 2 сартай эрэгтэй 1995-2019 онд зах дээр хувиараа хөдөлмөр эрхэлж, хувь хүний орлогын албан татвар төлөгчөөр бүртгүүлэн уг татварыг төлсөн тохиолдолд тухайн иргэн өндөр насны бүрэн тэтгэврийг 60 насандаа тогтоолгох бол шимтгэл төлсөн байвал зохих доод хугацаа 20 жил 9 сард ногдох шимтгэлийг 10 458 000 төгрөг (42000 төг х 249 сар)-өөр тооцож нөхөн төлүүлнэ. Тухайн иргэн өндөр насны тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгох хүсэлтэй бол хуульд заасан шимтгэл төлсөн байвал зохих доод хугацаа болох 10 жилд ногдох шимтгэлийг 5 040 000 төгрөг (42000 төг х 120 сар)-өөр тооцон төлүүлнэ.*

5.10. Нийгмийн даатгалын байгууллага (байцаагч) нь энэ зааврын 5.1-д заасан иргэний төлөгдөөгүй тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх хугацааг шалган тогтооход БСШУСЯ, ТЕГ, ЦЕГ, ХХҮЕГ, ШШГЕГ-аас авсан цахим мэдээлэл болон лавлагааг тус тус үндэслэнэ.





Санамж<sup>8</sup>: Нийгмийн даатгалын байцаагч нь иргэний холбогдох баримт бичигт үндэслэн өмнө нь тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг “Нөхөн” мэдээллийн санд шалгаж, нөхөн төлөх боломжтой жил, сарыг гарган, төлбөл зохих нийт шимтгэлийн дүнг тооцон, тухайн иргэнд төлөх шимтгэл, хугацаа, тэтгэвэр тогтоолгох эрх хэрэгжих зэрэг асуудлаар тодорхой зөвлөгөө өгч ажиллана.

5.11. Энэ зааврын 5.1.1-д заасан малчин нь нийгмийн даатгалын байгууллага (байцаагч)-д дараах баримт бичгийг бүрдүүлэн ирүүлж, тэтгэврийн даатгалын шимтгэл нөхөн төлөх хугацаагаа тооцуулна:

5.11.1. Иргэний үнэмлэх, түүний хуулбар;

5.11.2. Хөдөлмөрийн дэвтэр (шаардлагатай тохиолдолд ажилд орсон, ажлаас чөлөөлсөн тухай тушаал, шийдвэрийн архивын лавлагаа, 1990 оноос өмнө ажилласан хугацааг сэргээн тогтоосон тухай шүүхийн шийдвэр);

5.11.3. Баталгаажсан нийгмийн даатгалын дэвтэр (шаардлагатай тохиолдолд тухайн нийгмийн даатгалын хэлтсийн архивын лавлагаа);

5.11.4. Хугацаат цэргийн алба хаасан тухай цэргийн үнэмлэх, батлах (шаардлагатай тохиолдолд холбогдох цэргийн байгууллагын архивын лавлагаа);

5.11.5. Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулийн дагуу олгосон баталгаажилтын хуудас;

5.11.6. Тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлөх хугацаанд оршин сууж байсан болон одоо оршин суугаа сум (баг), дүүрэг (хороо)-ийн Засаг даргын тодорхойлолт;

5.11.7. “Мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн ...оны тооллого”-ын бүртгэл “А” дансны архивын лавлагаа;

5.11.8. 1995 оноос хойшхи энэ зааврын 5.11.7-д заасан “А” данс үрэгдсэн тохиолдолд “Даатгуулагчийн малчнаар ажиллаж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тодорхойлох зөвлөл”-ийн тогтоол (эх хувь, хуулбарын хамт);

5.11.9. Тэтгэврийн даатгалын санд бүрэн төлсөн орлогын мэдүүлэг (баримт) зэрэг болно.


5.12. Энэ зааврын 5.1.2-т заасан хувиараа хөдөлмөр эрхлэгч нь тэтгэврийн даатгалын шимтгэл нөхөн төлөх хугацаагаа тооцуулахдаа энэ зааврын 5.11.1-5.11.6-д заасан баримт бичгээс гадна доор дурдсан баримт бичгийг бүрдүүлж, нийгмийн даатгалын байгууллага (байцаагч)-д ирүүлнэ:

5.12.1. Тэтгэврийн даатгалын санд шимтгэлийг бүрэн төлсөн орлогын мэдүүлэг (баримт);

5.12.2. Тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлөх хугацаанд хувь хүний орлогын албан татвар төлөгч байсныг нотлох доор дурдсан баримт бичиг:

5.12.2.1. татвар төлөгч иргэний орлого, татварын бүртгэлийн дэвтэр;

5.12.2.2. татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд үндэслэн гаргасан татвар төлсөн татварын байгууллагын тодорхойлолт эсхүл лавлагаа зэрэг болно.





5.13. Нийгмийн даатгалын байцаагч нь иргэний хүсэлтийг хүлээн авч, баримт бичгийг нягтлан шалгасны үндсэн дээр холбогдох мэдээллийг мэдээллийн санд оруулан, шимтгэлээ төлөх хугацааг тухайн тохирч, шимтгэлийг нь бүрэн төлүүлснээр тухайн иргэний мэдээллийг баталгаажуулна.

5.13.1. Аймгийн нийгмийн даатгалын хэлтэс нь сумаас ирүүлсэн хүсэлт гаргасан иргэдийн хувийн хэргийг нягтлан шалгаж тухайн иргэний нөхөн төлөх боломжтой хугацаа болон төлөх шимтгэлийн дүнг тооцон сар бүр сумдад хүргүүлнэ.

5.13.2. Сумын нийгмийн даатгалын байцаагч холбогдох мэдээллийг иргэнд өгч, шимтгэлийг нь тэтгэврийн даатгалын санд бүрэн төлүүлэх ажлыг хариуцна.


5.14. Нийгмийн даатгалын ерөнхий газар “Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэний тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх журам”-ын 7.1-д заасан тайланг хянан шалгасны үндсэн дээр “Баталгаажилтын хуудас” (тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцсон тухай тэмдэглэлийн хамт)-ыг албажуулан сар бүрийн 30-ны өдрийн дотор холбогдох нийгмийн даатгалын хэлтсүүдэд хүргүүлнэ.

5.14.1. Аймгийн нийгмийн даатгалын хэлтэс нь “Баталгаажилтын хуудас”-ыг сар бүр сумдад хүргүүлэх ажлыг зохион байгуулна.

5.15. Шимтгэл нөхөн төлсөн иргэний баталгаажсан хугацааг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасан тэтгэвэр тогтоолгох болзол, нөхцөлийг хангасан даатгуулагчид зөвхөн шинээр тэтгэвэр тогтооход баримтална. Тахир дутуугийн тэтгэвэр тогтоолгон авч байсан иргэний тэтгэврийг шимтгэл нөхөн төлсөн хугацаагаар мөн хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу өөрчлөн тогтоохгүй.

#### ЗУРГАА. Хариуцлага

6.1. Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хууль, Засгийн газрын 2019 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэний тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх журам” болон энэ зааврыг зөрчсөн гэм буруутай этгээдээр учирсан хохирлыг нөхөн төлүүлж, хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.



Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын  
2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн  
А/06 тоот тушаалын хоёрдугаар хавсралт



**ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙГ НӨХӨН ТӨЛӨХ ХҮСЭЛТ**

(Нийгмийн даатгалын ажилтаны тэмдэглэл, дардас)

Хүсэлтийн дугаар	
НД-ын дэвтрийн дугаар	

2020 он ... сар ... өдөр

Миний бие энэхүү хүсэлт, түүнд хавсаргах малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэл нөхөн төлөхтэй холбогдох баримт бичгийн үнэн зөвийг бүрэн хариуцах бөгөөд энэ үүргээ зөрчсөнөөс учирсан хохирлыг бүрэн барагдуулна.

**ХҮСЭЛТ ГАРГАГЧИЙН**

Ургийн овог ..... Эцэг (эх)-ийн нэр ..... Өөрийн нэр .....

Регистрийн дугаар: .....

Холбоо барих утасны дугаар : ..... Одоогийн оршин суугаа хаяг : .....

Яаралтай үед холбоо барих утасны дугаар: .....

Тухайн нөхөн тооцох хугацаанд оршин сууж байсан хаяг: .....

**ХҮСЭЛТ ГАРГАХ ҮНДЭСЛЭЛ**

Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг:

4.1 Энэ хуулийн үйлчлэлд 1995 оноос энэ хууль хүчин төгөлдөр болсон өдөр хүртэл хугацаанд малчнаар ажилласан болон хувиараа хөдөлмөр эрхэлж байсан 15-60 насны иргэн хамаарна

Малчин


Хувиараа хөдөлмөр эрхлэгч

Иргэний хүсэлт гаргах үед тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн хугацаа ..... үүнээс (малчнаар ..... жил ..... сар)

Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэл нөхөн төлөх хугацаа:

Он	Сарууд												Нийт	Төлсөн мөнгө	
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12			
1995															
1996															
1997															
1998															
1999															
2000															
2001															
2002															
2003															
2004															
2005															
2006															
2007															
2008															
2009															
2010															
2011															
2012															
2013															
2014															
2015															
2016															
2017															
2018															
2019															
<b>Бүгд</b>	(Нийт ..... жил..... сар, төлсөн шимтгэл ..... төгрөг малчнаар ..... жил ..... сар, төлсөн шимтгэл ..... төгрөг)												Үүнээс		

(Хүсэлт гаргагч нь өөрт хамаарахыг малчин бол /М/, хувиараа хөдөлмөр эрхлэгч бол /Х/ гэж тэмдэглэнэ)

Дээрхи хугацаанд ногдох тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцож өгнө үү.  
Хүсэлт гаргагч би нөхөн төлбөл зохих тэтгэврийн даатгалын шимтгэлийг нэг удаа  
бүрэн төлөх үүргийг хүлээж байна.

Гарын үсэг..... / гарын үсгийн тайлал/ .....

(доорхи хэсгийг тасалж мэдүүлэг гаргагчид өгнө)

Хүсэлт хүлээн авсан ..... аймаг (дүүрэг)-ийн

НД-ийн хэлтсийн ажилтан: ..... / ..... /  
(байцаагчийн гарын үсэг, дардас)

Хувийн дугаар: / .....

Хүсэлт хүлээн авсан огноо: ..... Хүсэлтийн дугаар .....





